

ТЭРГҮҮН БАЙР ЭЗЭЛСЭН ЭССЭ

ЭХ ОРОНЧ ҮЗЭЛ- ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАТАЛГАА

Амарсайхан овогтой Саранжил
Нийслэлийн Сүхбаатар дүүргийн
11 дүгээр сургуулийн 10^а ангийн сурагч

“Илтгэх урлаг-хөтлөгч”-ийн дугуйланд явж байхдаа яруу найрагч О.Дашбалбарын “Өвөг дээдсээсээ бид эх орноо хүлээж авсан” гэдэг шүлгийг тогтоож билээ. Ёстой л үг бүрийг нь зүрх сэтгэлдээ шингээн байж уншсансан. Эх оронч үзлийг нэвт шингээсэн шүлэг гэдэгт дугуйлангийнхан маань ч, би ч ерөөсөө эргэлздэггүй. Нээрээ эх оронч үзэл гэж ярих дуртай ч бусдад энэ тухай хэлэх гэхээр эвлэж өгөхгүй нь сонин. Энэ үгийн утгыг “Их тайлбар толь”-иос хайж үзэхэд:

- Нутаг орноо гэх үзэл
- Эх орноо хайрлах сэтгэлтэй байх гэсэн байв.

Мэдээж үндэсний аюулгүй байдал гэдгийг улс орны хэмжээнд хор хөнөөлгүй байх гэж ойлгож байгаа.

Минийхээр зөв үйлдлээр илэрсэн эх оронч үзэл л үндэсний аюулгүй байдлыг хамгаалах гүүр болж чадна. Эх оронч үзлийн тухай унших дуртай шүлгийнхээ үг, өгүүлбэрээс хайя.

Эх оронч үзлийн нэг илэрхийлэл нь газар шороогоо хайрлах явдал. Тусгаар тогтнол бол газар шороо, хил хязгаар. Тусгаар тогтнол гэдэг бол бүх талаар бие даан, хэнээс ч юунаас ч хараат бусаар оршин тогтнох явдал. Үүнийг зохиолч О.Дашбалбар:

“Туг, сүлд, тусгаар тогтнол

Тулгын гурван чулуу тулсан голомтоо

Өвөг дээдсээсээ бид хүлээж авсан

Үр ачдаа бид хүлээлгэж өгнө” гэж тэрлэсэн. Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын бэлгэ тэмдэг нь төрийн сүлд, туг, далбаа, тамга, дуулал мөн.” гэж заасныг бид мэднэ. Тэгвэл төрийн сүлд, далбааныхаа учир холбогдлыг мэддэг, төрийн дууллаа бүрэн бүтэн дуулчихдаг байх нь эх оронч үзлийн илэрхийлэл гэж би бодож байна.

Эх оронч үзлийн бас нэг илэрхийлэл нь их түүхээ дээдлэх явдал. Зохиолч үүнийг

“Тужийн нарснаас эхэлсэн хувьсгалын түүх

Туган дээрх эртний бичээс, Сүхбаатарын гэрээстэй

Гучин ес, дөчин таван оны гуйвж дайваагүй ялалтын гэрчтэй эх орноо

Сансарт ниссэн гавьяа, атрыг хагалсан түүхтэйгээ хүлээлгэж өгнө” гэж шүлэглэжээ. Түүхийн ухааны доктор З.Батсайхан “Түүх бол тухайн үндэстний ой санамж” гэсэнтэй би санал нийлдэг. Яагаад гэвэл түүх алдааг хэлж, бидэнд сургамж үлдээдэг болохоор л тэр. Бид л түүхээ судалж, бахархахгүй юм бол өөр хэн гэж.

Эх оронч үзлийн нэг илэрхийлэл нь эх хэл, бичиг соёлоо эрхэмлэн дээдлэх явдал. Үндэсний соёл нь эх хэл бичгээр дамжин бидэнд ирдэг. “Соёлын өв гэдэг нь түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах байгаль, нийгэм, түүх, соёл урлаг, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий зүйлийг хэлнэ” гэсэн миний мэддэг тодорхойлолтыг энэ шүлэгт:

Соёмбот тугаа гурван зууны тэртээгээс бидэндээ ирүүлсэн

Цогт хун тайжийг ч

Сод ухаанаа “Хөх судар”-таа үлдээж, хойч үедээ илгээсэн

Суу билигт Инжинашийг хүлээж авсан шигээ хүлээлгэж өгнө” гэж илэрхийлжээ. Эх хэлээ зэрэмдэглэхгүй цэвэр ариун байлгах нь, зөв ёс зүйтэй хэрэглэх нь сурагч бидний үүрэг.

Эх оронч үзлийн бас нэг илэрхийлэл нь бүтээлч хөдөлмөр. Үүнийг шүлэгт өгүүлэхдээ:

“Ус нутгаа улам сайхан болгож

Тэнгэрээ цэлмэг, нараа тунгалаг хүлээлгэж өгнө” гэжээ. Ус нутгаа улам сайхан болгоно гэдэг бол мэдсэн сурснаа бүтээн байгуулалт болгохын нэр шүү дээ. Бүтээлч, үнэнч хөдөлмөр үндэсний аюулгүй байдлыг хамгаалах гол гүүр гэж би харж байна. Яагаад гээч? Үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж, түүнийг хэрэглэх нь улс орны хөгжил, хүн ардын амьдралын түвшинг сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулахаас гадна үндэсний аюулгүй байдлыг хангахад нөлөөлөх нь тодорхой.

Эх оронч үзлийн нэг илэрхийлэл нь байгаль эхээ хайрлах явдал.

“Алтай, хангай, говь, талаа чулуу бүхэнтэй нь

Өвс ногоо, шорооных нь ширхэг бүхэнтэй

Алтан нар, мөнгөн сарыг тоолохын аргагүй од мичидтэй нь

Хөвсгөл, Увс, Буйрыг усных нь дусал, загас бүхэнтэй нь

Хөөцөлдөн наадах долгисыг нь хүртэл

Өвөг дээдсээсээ бид хүлээж авсан, үр ачдаа хүлээлгэж өгнө.” гэсэн шүлгийн бадгаас энэ санаа харагдаж байгаа биз. Хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн гэж Үндсэн хуульдаа заасан байгаа. Орчноо цэцэрлэгжүүлэх сайн үйлсийн аяныг ахлах ангийнхан бид зохион байгуулвал Үндсэн хуульд заасан журамт үүргээ биелүүлж байгаа хэрэг. Цэцэрлэгжүүлэх нь өөрөө хөдөлмөр. Хөдөлмөрийн үр дүн нь эрүүл мэндэд нөлөөлөх эерэг нөлөө. Хуулин дахь журамт үүрэг нь хүртэл нэг нь нөгөөтэйгөө шууд хамааралтай байгаа биз.

Нээрээ буруу ойлголтгоо зөв болгох нь ч бас эх оронч үзэл. “Эх оронч” үзлийн тухай 460 гаруй тодорхойлолт байдгийг мэдэж авлаа. Тухайлбал: АНУ-д “Татвар төлөгч шударга иргэн бол эх оронч үзэлтэн” гэж тодорхойлдог байна. “Эх оронч үзэл татвар төлөхөөс эхэлнэ” гэсэн нэвтрүүлэг үндэсний татвар төлөгчдийн өдөр телевизийн сувгуудаар гарч байсан нь дээрх тодорхойлолтыг батлах шиг. Үндсэн хуульдаа ч иргэн хүн хуулиар ногдуулсан албан татвар төлөх ёстой гэж заасан байгаа. Эндээс харахад, хууль ёсыг дээдлэх нь эх оронч үзэл яалт ч үгүй мөн.

2010 оны 7 дугаар сарын 15-ны өдөр баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Үндэсний түүх, хэл, соёл, өв уламжлал, зан заншлаа хадгалж, хамгаалж хөгжүүлэх нь монгол үндэстний оршин тогтнохын үндэс, амин чухал дархлаа мөн.” гэсэн нь эх оронч үзэл, үндэсний аюулгүй байдал хоёрын амин холбоог харуулж байна.

“Эх оронч үзэлтэй хүн би” гэж цээжээ дэлдэж, бусдыг шүүмжлээд байх нь, “Үндсэрхэг үзэл” гэж чанга дуугаар хашгирч байгаа хүнийг “Энэ эх оронч үзэлтэй хүн” гэж андуурч ойлгоод байх нь, “Дэлхийд ганцхан Монголчууд” гээд чарлаад байх нь надад нэг л зохисгүй санагддаг. Үүнийг шүүмжилж “Өөрийн үндэстнийх бол чанарыг харгалзахгүй магтаж, бусад үндэстнийх бол чанарыг харгалзахгүй жигшиж байдаг нь эх оронч үзэл биш” гэж зохиолч Ц.Дамдинсүрэн гуай хэлсэн байдаг юм билээ. Үндсэрхэг үзэлтэн өнгөрсөн түүх ярьдаг. Чингүнжав, манлай ван Дамдинсүрэн гээд л...Харин эх оронч үзэлтэн одоо болж буй зүйлд дуу хоолойгоо хүргэж, бас өөрөө хийж, үлгэрлэж, ирээдүйрүүгээ тэмүүлдэг.

Эх оронч үзэл гэдгийг үгээр илэрхийлэх юм уу, эсвэл сэтгэл дотроо тээгээд явахад болох зүйл гэж би л хувьдаа бодохгүй байна. Сурагч бидэнд ч хийж бүтээх, оролцох, хэвшүүлэх зүйл гэж бий. Үүнд:

- Сурахад тууштай, зорилготой байх;
- Өөрөөсөө насаар ах эгч хэнийг ч хүндэлдэг, тэгш харьцдаг байх;
- Сэтгэлийн хаттай байх /Сэтгэлийн бөхөөр 1000-ыг дийлнэ гэдэг/;
- Орчноо цэвэр байлгах, эмх цэгцтэй байдалд хэвших;
- Цагийн үнэ цэнийг ухаарах, хичээлээсээ хоцрох, таслах үйлдэл гаргахгүй байх;
- хичээлийн цагийг үр дүнтэй өнгөрүүлэх /Хурд физик хэмжигдэхүүн болиод удаж байгаагийн нэг илрэл нь цаг хугацаа/;
- Өөрийн сул талаа давуу тал болгоход анхаарах.

Эцэст нь хэлэхэд, хандлагаа л өөрчлөх. Хандлага бодлоор илэрч үйлдлээр баталгааждаг. Зөв үйлдлээр илэрсэн эх оронч үзэл л үндэсний аюулгүй байдлыг хамгаалах гүүр болж чадна гэж дээр хэлсний цаад утга учир нь зөв хандлага. Үндэсний аюулгүй байдлыг хангахад хувь нэмрээ оруулъя гэвэл хандлагаа л өөрчилъе.

Ашигласан ном, цахим эх сурвалж:

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992
- Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010
- Түмэндэмбэрэл.Д “ Үндэсний үзэл, эх оронч үзэл” 2015
- Нандинбилиг.Г “Уран зохиол-VIII” УБ., 2017
- Нандинбилиг.Г “Яруу найргийг задлан шинжилж заан сургахуй” УБ.,2012
- <http://toli.query.mn/>
- <https://bayartsetseg.mn/>
- <http://buddha.mn/> Үнэт зүйлээ эрхэмлэх нь монгол хүний оршихуйн үндэс
- https://www.google.com/search?q=эмх+цэгцтэй+зан+эсрэг+чанар&ie=utf-8&oe=utf-8&client=firefox-b&gfe_rd=cr&ei=8AgVWZzPD6
- <https://www.slideshare.net/khotiinsoyol/ss-33832553>
- <https://prezi.com/login/?next=https%3A%2F%2Fprezi.com%2Fdashboard%2F>
- <http://bagabandi.niitlech.mn/content/2959.shtml>
- http://mgl_tsatsaa.blog.gogo.mn/read/entry240472